"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 30 өдөр Дугаар 01 Хэрлэн сум

Компанийн бүтэц, зохион байгуулалт,
орон тооны дээд хязгаарыг шинэчлэн
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.4, Эрчим хүчний сайдын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн а/358 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр хавсралтаар, ажилтан, албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан орон тооны цомхотголд орж байгаа ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуульд заасан хугацаанд мэдэгдэл хүргүүлж, хөдөлмөрийн гэрээг холбогдох хуульд нийцүүлэн дуусгавар болгохыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД БҮСИЙН ТТР 374 ... 262865 ДОРНОД АЙМАГ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн
01 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374
ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Зохион байгуулалтын бүтцийн схем



"Дорнод бүсийн эрчим хүчний систем"
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 01
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

# "ДБЭХС" ТӨХК-ИЙН ӨӨРЧИЛСӨН ОРОН ТООНЫ ТОВЧОО

| д/д | Компанийн нэгж, хэсгийн нэр | Орон тоо | | | Бүгд |
|---|---|---|---|---|---|
| | | Удирдлага | Цехийн дарга, ИТА, албан хаагч | Ажилтан | |
| 1 | Удирдлага | 2 | | | 2 |
| 2 | Дотоод аудитор | | 1 | | 1 |
| 3 | Захиргаа, хүний нөөцийн хэлтэс | 1 | 6 | | 7 |
| 4 | Санхүү, эдийн засгийн хэлтэс | 1 | 11 | | 12 |
| 5 | Худалдан авах ажиллагаа, хангамж үйлчилгээний хэлтэс | 1 | 5 | | 6 |
| 6 | Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэс | 1 | 9 | | 10 |
| 7 | Техникийн бодлого, шуурхай ажиллагааны алба | 1 | 21 | | 22 |
| 8 | Эрчим хүч борлуулалтын хэлтэс | 1 | 14 | 37 | 52 |
| 9 | Сүхбаатар ЦТС салбар | 1 | 18 | 67 | 86 |
| 10 | Түлш дамжуулах цех | | 9 | 63 | 72 |
| 11 | Зуухан цех | | 13 | 103 | 116 |
| 12 | Турбин цех | | 13 | 63 | 76 |
| 13 | Хими цех | | 8 | 26 | 34 |
| 14 | Цахилгаан цех | | 13 | 38 | 51 |
| 15 | К-ДХА цех | | 12 | 19 | 31 |
| 16 | Механик засварын хэсэг | | 2 | 11 | 13 |
| 17 | Цахилгаан шугам сүлжээний цех | | 7 | 66 | 73 |
| 18 | Дулааны шугам сүлжээний цех | | 2 | 15 | 17 |
| 19 | Үйлчилгээний ажилтнууд | | | 14 | 14 |
| 20 | Автограж | | | 25 | 25 |
| | **БҮГД** | **9** | **164** | **547** | **720** |

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 02 сарын 11 өдөр Дугаар 02 Хэрлэн сум

Компанийн ажилтнуудад 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.6, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.17, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн а/529 дүгээр албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг харгалзан ажилтнуудад 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг 3 хүртэлх сараар тогтоосугай.

2.Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсийг батлагдсан санд багтаан холбогдох журмын дагуу тооцож олгохыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо (Б.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР037... 
ДОРНОД АЙМАГ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
# ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 23 өдөр Дугаар 03 Хэрлэн сум

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 71 дүгээр зүйлийн 71.3, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.3 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/1033 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг гуравдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг дөрөвдүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт бэлэн болгох хугацааг тавдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:
Т.Оюун- Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга
Гишүүд:
Э.Энхцэцэг-Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн
Б.Маналжав-Архив, бичиг хэргийн ажилтан

4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ерэн-Өлзийг сонгосугай.

5.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах өдрийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөр тус тус тогтоосугай.

6.Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, холбогдох материалуудыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА О.ХУЯГЦОГТ

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн 03 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 2628651 ДОРНОД АЙМАГ

## КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай;

2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны зардлын төсөв батлах тухай;

4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай;

6. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай;

8. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

_____oOo______

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

“ Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цаг “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд боллоо.

| | | |
|---|---|---|
| Хувьцаа эзэмшигчийн овог нэр: | ЭХЯ, | ТӨБЗГ |
| Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар | 62263051, | 51-262350, |
| Хувьцаа эзэмшигчийн мэйл хаяг | info@energy.gov.mn , | info@pcsp.gov.mn |
| Регистрийн дугаар | 5638089, | 6098169 |
| Эзэмшиж буй хувьцааны тоо | Эрчим хүчний яам 66%<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34% | |

Санал хураах арга: Энгийн

| № | Санал авах асуудлууд | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 2 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 3 | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны зардлын төсөв батлах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 4 | Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 5 | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай | ☐ | ☐ | ☐ |
| 6 | Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 7 | Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 8 | Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал | ☐ | ☐ | ☐ |

Заавар: Та өөрийн саналыг + тэмдгээр бичнэ үү.

| |
|---|
| Хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн<br><br>Нэр....................................................<br>Албан тушаал..................................<br>Гарын үсэг...................................... |
| Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо. цаг ......................................................... |
| Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг ............................/ / |

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Тооллогын комиссын дарга: Т.Оюун / Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /

Гишүүд: Э.Энхцэцэг / Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн/
Б.Маналжав / Архив, бичиг хэргийн ажилтан/

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

..........................................................................................................................................................................

..........................................................................................................................................................................

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн 03 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр: | “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК |
| Хаяг: | Дорнод аймаг, Хэрлэн сум, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн байр |
| Хурал хуралдах өдөр, цаг: | 2026.04.30-ны өдөр 10:00 цаг |
| Хурал хуралдах газар /хаяг, байршил/: | Эрчим хүчний яам /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр / |
| Хурлын төрөл: | Ээлжит |
| Хурал зарлагч: | Төлөөлөн удирдах зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: | 2026.03.23 |
| Олон нийтэд зарлах огноо: | 2026.03.26 |
| Бүртгэлийн өдөр: | 2026.04.10 |
| Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо: | 2026.03.26 |
| Хүргүүлсэн огноо: | 2026.03.26 |
| Хурлын даргын нэр: | Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ерэн-Өлзий |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр: | Комиссын дарга: Т.Оюун , Гишүүд: Э.Энхцэцэг, Б.Маналжав |
| Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/: | - Хурал хуралдуулах тухай шийдвэр<br>- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар<br>- Саналын хуудасны загварууд<br>- Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа |
| Баримт бичгийн хуудасны тоо: | ........... хуудас |

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

.......... оны ......... дүгээр сарын ........ –ны өдөр

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
дөрөвдүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД ... НИЙ-ХЭ... ТТР0374 ... 2628651 ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

**Компанийн оноосон нэр:** “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

**Хаяг:** Дорнод аймаг, Хэрлэн сум, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн байр

**Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:** “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт

**Бүртгэлийн өдөр:** 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны зардлын төсөв батлах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай;

**Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам:**

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 09:30- 17:30 цагийн хооронд 88094897 утсаар болон Эрчим хүчний яамны байранд ирж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Т.Болортуяагаас цахим хэлбэрээр авч танилцаж болно.

**Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалууд
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 13-ны
өдрийн 03 дугаар тогтоолын
тавдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ... ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ... ТТР0374 ... 262861 ... ДОРНОД АЙМАГ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН МЭДЭЭЛИЙН ЖАГСААЛТ БЭЛЭН БОЛГОХ ЭЦСИЙН ХУГАЦАА

| № | Хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл | Бэлэн болох хугацаа |
|---|---|---|
| 1 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол | 2026.03.23 |
| 2 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл | 2026.03.26 |
| 3 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар | 2026.03.26 |
| 4 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас | 2026.04.24 |
| 5 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай | 2026.03.31 |
| 6 | Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай | 2026.03.31 |
| 7 | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайлан, 2026 оны зардлын төсөв батлах тухай | 2026.03.31 |
| 8 | Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах. | 2026.03.31 |
| 9 | Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай | 2026.03.31 |
| 11 | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай | 2026.03.31 |

_____oOo______

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
зургаадугаар хавсралт

# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ”ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд болно.

| Д/д | Хэлэлцэх асуудлын дараалал | Гарах шийдвэр | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Бүртгэлийн үйл ажиллагаа<br>Хурлын ирцийг бүртгэх, мэдээлэх | - | 10:00-10:05 | Тооллогын комисс |
| 2 | Хурлын нээлт<br>-Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах | - | 10:05-10:10 | Хурлын дарга |
| 3 | Хэлэлцэх асуудал-1<br>Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 10:10-10:15 | Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан<br>Ерөнхий нягтлан бодогч Б.Энхбаатар |
| 4 | Хэлэлцэх асуудал-2<br>Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 10:15-10:20 | ТУЗ-ийн дарга О.Хуягцогт |
| 5 | Хэлэлцэх асуудал-3<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайлан, 2026 оны зардлын төсвийн төсөв батлах тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 10:20-10:25 | ТУЗ-ийн дарга О.Хуягцогт |
| 6 | Хэлэлцэх асуудал-4<br>Ногдол ашгийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 10:25-10:30 | Ерөнхий нягтлан бодогч Б.Энхбаатар |
| 7 | Хэлэлцэх асуудал-5<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 10:30-10:35 | Нэр дэвшүүлэх түр хорооны дарга |
| 8 | Хэлэлцэх асуудал-6<br>Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай<br>-асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 10:35-10:40 | Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан |
| 9 | Хэлэлцэх асуудал-7<br>Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Тогтоол | 10:40-10:45 | ТУЗ-ийн дарга О.Хуягцогт |
| 10 | Санал хураалт | - | 10:45-10:50 | Тооллогын комисс |
| 11 | Хурал хаах | - | 10:50-10:25 | Хурлын дарга |

_____oOo______

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 03 өдөр Дугаар 09 Хэрлэн сум

Компанийн дүрэмд өөрчлөлт
оруулах тухай

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/1033 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /ерөнхий нягтлан бодогч/, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга, Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга, Сүхбаатар ЦТС салбарын даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэснийг “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /ерөнхий нягтлан бодогч/, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, Худалдан авах ажиллагаа, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга, Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга, Эрчим хүч борлуулалтын хэлтсийн дарга, Сүхбаатар ЦТС салбарын даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэж өөрчлөлт оруулахыг дэмжсүгэй.

2.Компанийн дүрмийн өөрчлөлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (О.Хуягцогт)-д даалгасугай.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 262865 ДОРНОД АЙМАГ ДОРНОД БҮСИЙН

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
# ТОГТООЛ

2026 оны 04 сарын 03 өдөр | Дугаар 05 | Хэрлэн сум

## Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6, 80 дугаар зүйлийн 80.2, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 4.1, 4.4 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/1033 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр 27,755,617,690.42 (хорин долоон тэрбум долоон зуун тавин таван сая зургаан зуун арван долоон мянга зургаан зуун ерэн төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2.Ногдол ашгийн тухай шийдвэрийг холбогдох материалын хамт Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ДОРНОД БҮСИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374 … 262865
ДОРНОД АЙМАГ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 03 өдөр Дугаар 06 Хэрлэн сум

Гүйцэтгэх захиралтай байгуулсан
Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн
гэрээний биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9, 80 дугаар зүйлийн 80.2, 83 дугаар зүйлийн 83.6 дахь хэсэг, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх журам”-ын 2.1, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.10 дахь заалт, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханы 2025 онд Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хавсралтаар баталсугай.

2.Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханы 2025 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 93.4 оноогоор “Сайн” гэж дүгнэсүгэй.

3.Гүйцэтгэх захирлын Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн даргад тус тус даалгасугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн
06. дугаар тогтоолын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД ҮҮСИЙН СИСТЕМ ТӨХК-ИЙН ТТР0374 262865 ДОРНОД АЙМАГ

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН 2025 ОНЫ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮГНЭЛТ

| № | Үзүүлэлтүүд | хэмжих нэгж | 2025 он | | Төлөвлөгөөтэй | | Оноо | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөв | гүйцэтгэл | зөрүү | хувь | Авбал зохих | Авсан |
| 1 | **Эдийн засгийн үзүүлэлт** | | | | | | **50** | **45.2** |
| 1.1 | Боловсруулсан ЦЭХ | сая.кВтц | 386.3 | 378.0 | (8.3) | 97.9 | 5 | 4.9 |
| | Нийт түгээх ЦЭХ | сая.кВтц | 373.6 | 372.9 | (0.8) | 99.8 | | |
| | Өөрийн түгээх ЦЭХ | сая.кВтц | 332.0 | 324.3 | (7.7) | 97.7 | | |
| | ХАЦЭХ | сая.кВтц | 41.2 | 48.2 | 7.0 | 116.9 | | |
| | Импортын ЦЭХ | сая.кВтц | 0.434 | 0.447 | 0.012 | 102.8 | | |
| | Түгээх ДЭХ | мян.Гкал | 352.3 | 366.8 | 14.4 | 104.1 | | |
| 1.2 | Нийт орлого | сая.төг | 111,070.0 | 109,463.8 | (1,606.2) | 98.6 | 5 | 4.9 |
| | Үүнээс: Борлуулалтын орлого | сая.төг | 110,492.2 | 108,365.2 | (2,127.0) | 98.1 | | |
| 1.3 | Нийт зардал | сая.төг | 136,710.0 | 137,219.4 | 509.4 | 100.4 | 5 | 4.9 |
| 1.4 | Татвар төлөхийн өмнөх ашиг | сая.төг | (25,640.0) | (27,755.6) | (2,115.6) | 108.3 | 10 | 5.9 |
| | ААНОАТатвар | сая.төг | - | - | - | 0.0 | | |
| | Цэвэр ашиг /алдагдал/ | сая.төг | (25,640.0) | (27,755.6) | (2,115.6) | 108.3 | | |
| 1.5 | БО-ын 1 төгрөгт ногдох зардал | төг | 1.231 | 1.254 | 0.023 | 101.8 | 5 | 4.6 |
| 1.6 | Нийт авлага | сая.төг | 4,154.5 | 3,916.7 | (237.8) | 94.3 | 5 | 5 |
| 1.7 | Нийт өглөг | сая.төг | 240,173.8 | 243,407.3 | 3,233.5 | 101.3 | 5 | 5 |
| | Үүнээс: Богино хугацаат өглөг | сая.төг | 34,434.0 | 33,950.3 | (483.7) | 98.6 | | |
| 1.8 | Хөрөнгө оруулалт, их засвар,ТЗБАХ | сая.төг | 4,107.9 | 3,888.2 | (219.8) | 94.7 | 5 | 5 |
| 1.9 | Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл, улс орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх | сая.төг | - | - | - | - | 5 | 5 |
| 2 | **Тайлангийн үр дүн** | | | | | | **20** | **20** |
| 2.1 | Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт | - | | | | | 6 | 6 |
| 2.2 | Шийдвэрийн хэрэгжилт /ЭХЯ, ТӨБЗГ, Эрчист монгол ХХК/ | - | | | | 100% | 5 | 5 |
| 2.3 | Шилэн дансны хууль тогтоомжийн биелэлт болон Аудитын сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт | - | | | | | 5 | 5 |
| 2.4 | Хэрэглэгчийн санал асуулгын дүн | Хэрэглэгчийн тоо | 402 | - | 402 | 100% | 2 | 2 |
| 2.5 | Ажилтнуудын санал асуулгын дүн | Ажилтны тоо | 485 | - | 485 | 100% | 2 | 2 |
| 3 | **Техникийн үзүүлэлт** | | | | | | **30** | **28.2** |
| 3.1 | Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ | гр/кВтц | 557.317 | 543.567 | (18.846) | | 5 | 5 |
| | ДЭХ | кг/Гкал | 191.353 | 190.958 | (1.274) | | | |
| 3.2 | Дотоод хэрэгцээний цахилгааны зарцуулалтын хувь | хувь | 13.03% | 14.21% | 1.18% | | 5 | 4.5 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын хувь | хувь | 4.5% | 6.2% | 1.7% | 73.2 | 5 | 3.7 |
| 3.4 | Нэмэлт усны зарцуулалт | мян.м3 | 100.9 | - | (10.0) | 91 | 5 | 5 |
| 3.5 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, технологийн зөрчил | - | - | - | - | - | **10** | **10** |
| | **НИЙТ ДҮН** | | | | | | **100** | **93.4** |

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 03 өдөр Дугаар 07 Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80.2 дахь хэсэг, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн дүрмийн 7.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/1033 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг 174,549,800.00 (Нэг зуун далан дөрвөн сая таван зуун дөчин есөн мянга найман зуу) төгрөгөөр тогтоож, хавсралт ёсоор дэмжсүгэй.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга нарт тус тус даалгасугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн
07 дугаар тогтоолын хавсралт

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| д/д | Зардлын төрөл | 2026 оны төлөвлөгөө /мян.төг/ |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн бүрэлдэхүүн | 10 |
| 2 | Цалингийн зардал | 145,200.0 |
| 3 | НДШ | 16,698.0 |
| 4 | Томилолтын зардал | 11,394.0 |
| 5 | Бичиг хэрэг | 540.0 |
| 6 | Хурал зохион байгуулах зардал | 717.8 |
| | Нийт дүн | 174,549.8 |

---oOo---

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 03 өдөр Дугаар 08 Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.9 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/1033 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн тогтоосон хугацаанд хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд, хурлыг тухай бүр журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Т.Болортуяад тус тус даалгасугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ДОРНОД БҮСИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374 262865
ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн
08 дугаар тогтоолын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ... ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ... ТТР0374 ... 262865 ... ДОРНОД АЙМАГ

# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/Д | Хугацаа | ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | 1 сар | 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний тухай | Гүйцэтгэх захирал |
| 2 | | Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай | ЗХНХ-ийн дарга |
| 3 | 2 сар | Компанийн ажилтнуудад 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдлийн тухай | СЭЗХ-ийн дарга |
| 4 | | 2025 оны худалдан авах ажиллагаанд хийсэн компанийн дотоод аудитын тайлан, дүгнэлтийг танилцуулах тухай | Дотоод аудитор |
| 5 | | Компанийн хүний нөөцийн нөхөн дүүргэлт, сонгон шалгаруулалт, томилгоонд хийсэн Дотоод аудиторын тайлан, дүгнэлт танилцуулах тухай | Дотоод аудитор |
| 6 | 3 сар | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайланг танилцуулах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 7 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 8 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төлөвлөгөөг дэмжих тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 9 | | ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудиторын 2025 оны ажлын тайланг танилцуулах тухай | Дотоод аудитор |
| 10 | | ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудиторын 2026 оны ажлын төлөвлөгөөг батлах тухай | Дотоод аудитор |
| 11 | | Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн тухай | СЭЗХ-ийн дарга |
| 12 | | Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг батлах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 13 | | Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үүрэг, зорилтот түвшингийн биелэлтийг хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгөх тухай | Гүйцэтгэх захирал |
| 14 | | Ногдол ашгийн тухай | Гүйцэтгэх захирал |
| 15 | 4 сар | Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө батлах тухай | Гүйцэтгэх захирал |
| 16 | | Компанийн 2025-2026 оны өвлийн их ачааллыг давсан тухай тайлан | Ерөнхий инженер |
| 17 | 5 сар | Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 18 | | Тусгай зөвшөөрөл олгогдсон эрхийн хүрээнд бодит зардалд суурилсан ажил, үйлчилгээний үнэ тариф тогтоосон байдал дотоод аудитыг хэрэгжүүлэх | ТУЗ-ын аудитын хороо<br>Дотоод аудитор |

| | | | |
|---|---|---|---|
| 19 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7,12 дугаар тэмдэглэлээр гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг бүрэн хангаж, шийдвэрлэх санал боловсруулан танилцуулах тухай | Гүйцэтгэх захирал |
| 20 | 7 сар | Компанийн 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, техник эдийн засгийн үзүүлэлтийн гүйцэтгэлийн тухай | СЭЗХ-ийн дарга |
| 21 | | Компанийн 2026 оны худалдан авах төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн тухай | ХААХҮХ-ийн дарга |
| 22 | 9 сар | Компанийн үндсэн хөрөнгө, хөрөнгийн ашиглалт, түүнтэй холбоотой авах арга хэмжээний тухай | СЭЗХ-ийн дарга |
| 23 | 10 сар | Компанийн 2026-2027 оны өвлийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан тухай | Ерөнхий инженер |
| 24 | 12 сар | Компанийн 2027 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ийн төлөвлөгөөний тухай | Гүйцэтгэх захирал |
| 25 | Жилд 1 удаа | Компанийн үйл ажиллагаа өөлон тулгамдсан асуудалтай газар дээр нь очиж танилцаж, шийдвэрлэх | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 26 | Тухай бүр | Цаг үеийн шаардлагатай асуудлыг тухайн үед нь хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмж оруулан, хэлэлцэн шийдвэрлэх | Холбогдох албан тушаалтан |
| 27 | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 81.4-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах | Аудитын хороо |
| 28 | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 81.5-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах | Нэр дэвшүүлэх хороо |
| 29 | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 81.6-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах | Цалин урамшууллын хороо |

---oOo---

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 03 өдөр    Дугаар 04    Хэрлэн сум

Компанийн 2025 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11,80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12 дахь заалт, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны 03 сарын 16-ны өдрийн 374 тоот дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/1033 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2025 онд техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлсэн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгснийг тус тус харгалзан компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (О.Хуягцогт)-д даалгасугай.

3.Төрийн аудитын газраас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө баталж, биелэлтийг хагас жил тутам Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА    О.ХУЯГЦОГТ